



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар A/239

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумалгааны автомашины агаарын хөлгийн шатахууны шүүр (ЧХОУНБШХА) нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны  
дарга:

Ц.Төрмөнх Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны ерөнхий инженер

Нарийн бичгийн дарга: Ч.Ганзориг Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн

Гишүүд:

Б.Гантулга Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны засварын инженер

Г.Цолмон Иргэний нисэхийн залуучуудын холбооны гишүүн

М.Оргил “Сэтгэл зүй, судалгаа мэдээллийн төв” Төрийн бус байгууллагын судлаач

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Ц.Төрмөнх)-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хургүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА

П.МОНХЖАРГАЛ

